



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 03 дугаар  
сарын 29-ны өдөр

Дугаар ХЭГ/462

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын бүтээн байгуулалтын ажлын явц, ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр болон бусад холбогдох зарим асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг,  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.ЭНХ-АМГАЛАНГААС ЕРӨНХИЙ САЙД  
У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

***Асуулт 1.** Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх буудлыг барихад зориулан Япон Улсын Засгийн газраас 20 гаруй тэрбум иен буюу 247 сая ам.долларын зээл авсан байдаг. Гэтэл 2016 оны байдлаар тус шинэ нисэх буудлын өртгийг 650 сая ам.доллар болгон нэмэгдүүлжээ. Засгийн газар зээл нэмэгдүүлсэн шалтгаан нөхцөлийг судалж үзсэн эсэх.*

**Хариулт:**

“Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийг санхүүжүүлэхээр тохирсон 28.8 тэрбум иенийн зээлийн хэмжээг 36.8 тэрбум иенээр нэмэгдүүлж, нийт 65.6 тэрбум иен (650 орчим сая ам.доллар)-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх болсон шалтгаан нөхцөлийг 2015 оны 2 дугаар сард Улсын Их Хурлын Эдийн засгийн, Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодын хуралдаанд тус тус танилцуулсны үндсэн дээр холбогдох шийдвэрийг гаргуулсан байна.

Дээрх шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайдын 2015 оны 93 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэмэлт зээлийн хэлэлцээр”-т гарын үсэг зурах эрх олгогдсоны дагуу Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр нэмэлт зээлийн гэрээг байгуулсан.

***Асуулт 2.** Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх буудалд ажиллах боловсон хүчний орон сууцны асуудлыг хэдэн он гэхэд бүрэн шийдвэрлэх, ямар хөрөнгийн эх үүсвэрээр орон сууц, сургууль, эмнэлэг, барих.*

**Харилт:**

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд үйлдвэр, үйлчилгээ, эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжуудыг барьж байгуулахаар тусгагдсан бөгөөд нисэх буудлын болон агаарын тээвэрлэгч нарын нийгмийн асуудал хамтдаа шийдвэрлэгдэхээр төлөвлөгдсөн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 105 дугаар тогтоолыг үндэслэн Барилга, хот байгуулалтын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга болон Төв аймгийн Засаг дарга нар 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын даалгавар”-ыг хамтран баталсны дагуу дээрх төлөвлөгөөг 2018-2030 он, 2030-2040 он гэсэн 2 үе шаттай барьж байгуулахаар тусган, тодотгол боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Гоби травел” ХХК шалгарч, шинэ хот байгуулах ажилд шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох ажлыг хийж байна.

***Асуулт 3.** Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх буудалд ерөнхий зориулалтын агаарын тээврийн үйл ажиллагаанд зориулагдсан нөхцөл бүрдсэн болон хөрөнгө оруулалт хийгдэж буй эсэх.*

### **Хариулт:**

Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал нь нисдэг тэрэг, бага оврын агаарын хөлгийн зогсоолыг багтаасан 108,800 квадрат метр талбай бүхий агаарын хөлгийн зогсоолтой, А380 хүртэлх том оврын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай 4Е ангиллын аэродром юм.

Мөн төслийн бүтээн байгуулалтын хүрээнд гэрэл суултын систем, цаг уурын автомат систем, навигацийн тоног төхөөрөмжүүдийн алсын удирдлага зэрэг агаарын навигацийн болон бусад холбогдох тоног төхөөрөмжүүд суурилагдаж дууссан бөгөөд ерөнхий зориулалтын агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах боломж бүрэн хангагдаад байна.

***Асуулт 4.** Өмнөх хоёр ч Засгийн газрын үед Зам, тээврийн яам Буянт-Ухаа дахь “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг нисэхийн чиглэлээр тухайлбал, ерөнхий зориулалтын нислэгийн чиглэлээр үргэлжлүүлэн ашиглах бодлогыг баримталж байсан бодлогыг хэвээр нь явуулах эсэх.*

### **Хариулт:**

Зам, тээврийн сайд /хуучин нэрээр/-ын зөвлөлийн 2016 оны 05 дугаар хуралдаанаар одоогийн “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг цаашид хэрхэх тухай асуудлыг авч хэлэлцээд нисэх буудлыг “Буянт-Ухаа” аэродром болгон өөрчилж, иргэний нисэхийн чиглэлээр үргэлжлүүлэн ашиглах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.

Шинэ нисэх буудлын үйл ажиллагаа эхлэхээс өмнө хуучин нисэх буудал дахь арилжааны нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх бөгөөд нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо навигацийн үйлчилгээ, оношилгоо, хэмжил зүйн лаборатори, нисэхийн мэдээллийн үйлчилгээ болон Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа улсын нисэхийн 303 дугаар анги “Буянт-Ухаа” аэродромд үлдэхээр төлөвлөж байна.

Иймд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, шаардлагад нийцсэн, салбарын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, мэргэжил, ур чадвар, туршлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлж, хуучин нисэх буудлыг иргэний нисэхийн чиглэлээр үргэлжлүүлэн ашиглах бодлогыг баримталж байна.

***Асуулт 5.** Дэлхий нийтэд агаарын тээврийн салбарын үйлчилгээ тэлж хөгжил хурдацтай явагдаж байгаагийн улмаас нисгэгчийн хомсдолд орж, тэдний эрэлт нэмэгдэж байна. Иймд чөлөөлөгдөж буй “Чингис хаан” нисэх буудлын иж бүрэн объектыг цаашид зориулалтаар нь дотоод, гадаадын нисэхийн мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалт, техник үйлчилгээний нэгдсэн төвийг бий болгож үйл ажиллагаа явуулах эсэх.*

### **Хариулт:**

Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д одоогийн “Чингис хаан” олон улсын нисэх буудалд нисэхийн төрөлжсөн олон улсын сургалт, дадлагын цогцолбор болон дотоод, гадаадын нисгэгчдийг бэлтгэх бааз суурийг байгуулан хөгжүүлэх, мөн төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд агаарын тээвэрлэгчдийн ангарын барилгыг түшиглэсэн бага оврын агаарын хөлгийн засвар үйлчилгээ, үйлдвэрлэлийн төвийг байгуулан хөгжүүлэхээр төлөвлөсөн.

Мөн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ерөнхий зориулалтын нисэхийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, агаарын зай, аэродром, буух талбай, нисдэг тэрэгний тавцан, агаарын хөлөг, бүртгэл, техник үйлчилгээ болон нисгэгч бэлтгэх зэрэг үйл ажиллагааны зохицуулалтыг хамарсан “Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлуулахаар ажиллаж байна.

*Асуулт 6. МИАТ-ын агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын /ангаар/ хамт олон өнгөрсөн онд гадаад улсын 50 дахь том оврын агаарын хөлөгт техник засвар үйлчилгээ хийж ашигтай ажилласан байна. Энэ засварын газрыг энэ чиглэлд нь өргөжүүлэх, эсвэл Хөшигийн хөндий рүү нүүлгэх эсэх.*

**Хариулт:**

“МИАТ” ТӨХК-иар агаарын хөлгийн засвар үйлчилгээ хийлгэх гадаад, дотоодын агаарын хөлгийн тоо жил ирэх тусам нэмэгдсэнээр инженер техникийн ажилчдын мэргэжлийн ур чадвар, байгууллагын үйл ажиллагааны орлого нэмэгдэхийн сацуу үндэсний агаарын тээвэрлэгчийн өрсөлдөх чадвар сайжрахад чухал нөлөөтэй байгаа тул одоогийн ангар, боловсон хүчний нөөцийг түшиглэн агаарын хөлгийн засвар үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх бодлогыг баримталж байна.

Мөн Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлд тусгагдсаны дагуу зээлийн үлдэгдэл хөрөнгөөр шинэ нисэх буудалд агаарын хөлгийн засвар үйлчилгээг хийх зориулалт бүхий ангарын барилгын зураг төсөл боловсруулах ажлыг төслийн зөвлөх компаниар гүйцэтгүүлж байгаа бөгөөд уг барилгыг 2019 оны 04 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа болно.

*Асуулт 7. Бүсийн нислэгийн удирдлагын төвийн барилгыг 2010 онд Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам 6 тэрбум төгрөгөөр барихаар төсөвлөн тендер шалгаруулан гүйцэтгүүлж 2012 онд 80 хувийн гүйцэтгэлтэй болсон байна. Гэтэл энэ барилгын ажил одоогоор зогссон байна. Энэ хугацаанд бус барилгыг барьж байсан компани шүүхэд алданги тооцон нэхэмжлэл гарган 4 тэрбум төгрөгийг шүүхийн шийдвэрээр авсан байна. Энэ ажлын алдаа эндэгдэлд шинжилгээ хийж хариуцлага алдсан хүмүүст хариуцлага ногдуулсан эсэх, цаашид ямар хөрөнгийн эх үүсвэрээр барьж дуусгах.*

**Хариулт:**

Иргэний нисэхийн тухай хуулийн 8.2 дахь хэсэгт заасан иргэний нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах, мөн хуулийн 24.3 дахь хэсэгт заасан Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх замыг холбоо, навигацийн төхөөрөмжөөр нислэгийн аюулгүй байдлыг хангах түвшинд тоноглогдсон байртай байх шаардлагын хүрээнд Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам /хуучин нэрээр/, “Үүрэг трейд” ХХК хооронд “Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлын гэрээ”-г 2011 онд, үндсэн гэрээний нэмэлт гэрээг 2013 онд тус тус байгуулсан.

Одоогоор уг барилгын ажлын гүйцэтгэл 82 хувийн биелэлттэй явж байгаа бөгөөд барилгын ажлын үндсэн гэрээний үлдэгдэл санхүүжилтийг Иргэний

нисэхийн ерөнхий газрын цэвэр ашгийн хөрөнгөөс санхүүжүүлэн гүйцэтгэх тухай нэмэлт, өөрчлөлтийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, барилгын ажлыг дуусгах арга хэмжээг авч ажиллаж байна.

---oOo---